



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР


АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.НАМЧИНСҮРЭН

2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр

АШИГ МАЛТМАЛЫН НӨӨЦ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ



Хүчин төгөлдөр АМ-ын тусгай зөвшөөрөлтэй талбай



Бүртгэгдсэн нөөц		
Ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	Нөөц
Зэс	сая тн	59.6
Нүүрс	тэрбум тн	39.7
Төмрийн хүдэр	тэрбум тн	2.1
Алт (ОТ ороогүй)	тн	562.8
Цайр	сая тн	5.1
Хайлуур жонш	сая тн	36.2
Уран	мян.тн	192.2
Газрын тос (Баталгаат)	сая тн	32.6

НИЙТ ГАЗАР НУТАГТАЙ ХАРЬЦУУЛАХАД (2025)

3.27%

ХАЙГУУЛЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ: 1031

1.22%

АШИГЛАЛТ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ: 1771



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

22%

2025 I-IX

АУ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

78%

2025 I-XI

ЭКСПОРТЫН ОРЛОГО

93%

2025 I-XI

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



74%

2025 I-IX

УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

27%

2025 I-X



ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

НҮҮРС

БИЕТ ХЭМЖЭЭ
(мян.тн)

2025*: 85 сая тн




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
(сая ам.дол)



ЗЭСИЙН БАЯЖМАЛ

БИЕТ ХЭМЖЭЭ
(мян.тн)

2025*: 2.0 сая тн




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
(сая ам.дол)



ТӨМӨР

БИЕТ ХЭМЖЭЭ
(мян.тн)

2025*: 8.1 сая тн




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
(сая ам.дол)




ЦАЙР

БИЕТ ХЭМЖЭЭ
(мян.тн)

2025*: 150 мян.тн




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
(сая ам.дол)




ХАЙЛУУР ЖОНШ

БИЕТ ХЭМЖЭЭ
(мян.тн)

2025*: 800 мян.тн



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
(сая ам.дол)




» ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Ашигт малтмалын тухай хуулийг анх 1997 онд баталж, 2006 оны 07 сарын 08 өдөр 11 бүлэг, 66 зүйлтэйгээр шинэчлэн найруулсан баталсан. 2009 онд 61, 2010 онд 15, 2011 онд 8, 2012 онд 28, 2013 онд 6, 2014 онд 79, 2015 онд 26, 2016 онд 16, 2017 онд 26, 2018 онд 3, 2019 онд 30, 2021 онд 2, 2022 онд 10 зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт орж байсан бөгөөд нийт 300 орчим өөрчлөлт орсон байна.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд 11 бүлэг 66 зүйлтэйгээр баталсан бөгөөд хууль хэрэгжих хугацаанд 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 11 бүлэг 59 зүйлийн хэсэг, заалтууд ямар нэгэн байдлаар хөндөгдсөн байна.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд:



НИЙТ - 209



» ХУУЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хүрээнд дараах асуудлуудыг хөндсөн. Үүнд:

1. Хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох;
2. Чухал ашигт малтмалын зохицуулалт;
3. Ашигт малтмалын баяжуулалтын үйл ажиллагаа;
4. Геологи, уул уурхайн салбар дахь олон нийтийн оролцоо;
5. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орон нутагт хүртэх өгөөж;



» ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТЫН ЗАРЧИМ

Олгох зарчим:

- ▶ Сонгон шалгаруулалт
- ▶ Өргөдөл

Өргөдлөөр олгох:

- ▶ улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнгээр ашигт малтмалын хэтийн төлөвгүй;
- ▶ нөөц тогтоогдоогүй буюу ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдоогүй, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эсэх нь тодорхойгүй, эдийн засгийн үр ашиг болон баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдоогүй;
- ▶ Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд 2 удаагийн сонгон шалгаруулалт зарлаж, оролцогч оролцоогүй бол өргөдлөөр олгох;


1997 оноос хойших тусгай зөвшөөрөл олголтын мэдээлэл

Нийт **16834** тусгай зөвшөөрөл
❖ Ашиглалтын **2546**
❖ Хайгуулын **14288**

Хайгуулын **14288** тусгай зөвшөөрөл
❖ Өргөдөл **13499**
❖ Сонгон **703**
❖ ЗГ-ын 216 дугаар тогтоолоор **51**
❖ ЗГ-ын тогтоолоор **35**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

ТЗ тоо



ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛ


Чухал ашигт малтмалын Ойлголт

- Дэлхийн 2-р дайны улмаас зэвсгийн аж үйлдвэрт метал түүхий эдийн хангалт тасалдах эрсдэлийг харж, **стратегийн нөөц бүрдүүлэхдээ “Чухал ашигт малтмал” тодорхойлолтыг АНУ анх ашигласан.**
- Цахилгаан бараа, өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дэлхий даяар борлуулдаг Япон зэрэг улс эрдэс **түүхий эд тасалдах эрсдэлээс сэргийлэх бодлого, Чухал ашигт малтмалын Жагсаалт гаргаж, яам агентлаг байгуулж эхлэв.**
- Эрчим хүчний шилжилт хийхэд 2020 - 2040 оны хооронд буюу **дунд хугацаанд эрдэс түүхий эд дутагдах эрсдэлийг хаахын тулд улс орнууд Чухал ашигт малтмалын асуудлыг хуульчилж, тэргүүлэх ач холбогдол өгч эхлэв.**



Чухал ашигт малтмалын Жагсаалт

- КОВИД-19-өөс хойш буюу сүүлийн 5 жилд ихэнх улс Чухал ашигт малтмалын жагсаалтаа шинэчилж, зарим улс шинээр жагсаалт зарлав. Европын Холбоо (2023), АНУ (2022, 2023*), Их Британи (2022), **Канад (2022), Энэтхэг (2023)**.
- Улс орнуудын Чухал ашигт малтмалын жагсаалтад 30 - 50 орчим элемент, метал багтаж байна. Эдгээрээс **20 орчим элемент бүх улсын жагсаалтад багтаж буй глобаль шинжтэй**. Тухайн улсын аж үйлдвэрийн онцлог хэрэгцээ ба түүхий эдийн олдоцоос шалтгаалсан **бүс нутаг ба орон нутгийн чанартай критикал гэж тодорхойлогдсон 20 гаруй элементүүд** байна.
- Батарейн түүхий эд (лители, кобальт, никель) болон газрын ховор элемент глобаль критикал байгаа бол цэвэр эрчим хүчний түүхий эд зэс сүүлийн 2 жилд глобаль критикал түүхий эд боллоо.



Чухал ашигт малтмалын Геополитик

- АНУ Энергийн Хууль (2020) “эдийн засгийн ба үндэсний аюулгүй байдалд гарцаагүй шаардлагатай, ханган нийлүүлэлтийн сүлжээ нь эмзэг, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чухал оролцоо бүхий тул Дотоод Хэргийн Сайд АНУ-ын Геологийн Албаны захирлаар дамжуулан критикал хэмээн зарласан аливаа эрдэс, элемент, бодис, болон материалыг Критикал Минерал хэмээнэ”.
- АНУ Инфляци Бууруулах Хууль: Дотоодод болон Чөлөөт Худалдааны Гэрээ бүхий түншүүдээс олборлосон түүхий эд ашиглан, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд татаас олгож байна.
- Эрдсийн Аюулгүй Байдлын Түншлэл (МСР). АНУ-ын санаачлагаар 2022 онд байгуулагдсан, 15 гишүүнтэй. Тухайлсан төсөл санхүүжүүлэх, хэрэгжүүлэх МСР Forum-д одоогоор Аргентин, БН Конго, БН Доминикан, Эквадор, Грийнланд, **Казакстан**, Мексик, Намиб, Перу, Филиппин, Серб, Түрк, Украин, **Узбекистан**, Замби улсууд нэгдсэн.

АНУ-тай Чөлөөт Худалдааны Гэрээ бүхий улс орнууд





Чухал ашигт малтмалын Геополитик

- **Net-Zero Аж үйлдвэрийн тухай хууль.** Европын Холбоо 2030 он гэхэд цэвэр эрчим хүч үйлдвэрлэх 20 орчим технологийг эзэмшиж, хэрэгцээний 40%-иа дотооддоо үйлдвэрлэнэ.
- **Критикал түүхий эд, материалын хууль.** Европын Холбоо 2030 он гэхэд жилд хэрэглэх стратегийн түүхий эдийн 10%-ийг дотоодоос олборлоно. **Стратегийн түүхий эдийн 65%-иас дээш хувийг аливаа нэг гуравдагч улсаас хараат байлгахгүй.**
- Франц, Итали зэрэг Европын улс орнууд критикал минералын эх үүсвэрээ баталгаажуулж хөрөнгө оруулалт хийх сан байгуулж эхэлсэн. **Францын Засгийн газар, хувийн хэвшил хамтарсан сан** (2.5 тэрбум евро) **чухал ашигт малтмалын төсөлд хөрөнгө оруулж, баталгаа гаргаж, бүтээгдэхүүнийг нь худалдан авах эрхээ баталгаажуулна.**

Европын Холбоо Хүлэмжийн хийн ялгаруулалт бууруулах зорилтоо чухал ашигт малтмалын бодлоготой уялдуулж байна.

Critical Raw Materials Act
EU Competitiveness



Үйлдвэрлэгч орнууд, түншүүд чухал ашигт малтмалын чиглэлээр хамтрах сонирголоо илэрхийлж байна

Mongolia to supply critical metals to France, Macron says

By Reuters

May 22, 2023 7:25 AM GMT+8 · Updated 2 years ago




Чухал ашигт малтмалын ШИНЭ БОЛОМЖ

- Экспортыг төрөлжүүлэх боломж. Хөгжлийн түнш орнуудын Монгол улстай харилцах дипломат бодлогод Чухал ашигт малтмалын асуудал тэргүүлэх байр суурь эзэлж байна.
- Аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх боломж. Чухал ашигт малтмалд суурилсан аж үйлдвэрийн шинэ гинжин хэлхээнд нэвтрэн орох, **midstream** шат уруу шилжихэд **хамтран ажиллах** хүсэл сонирхол илэрхийлэх тохиолдолд сонсох, хүлээн авч хамтран ажиллах улс орнууд бий болсон байна.
- Критикал минералын хайгуул, олборлолт, боловсруулалтыг эрчимжүүлэх боломж. Хоёр талт, олон талт хамтын ажиллагааны механизм ашиглан **Чухал ашигт малтмалын шинэ гинжин хэлхээнд нэвтрэн орсон тохиолдолд хайгуул, олборлолт, боловсруулалтын төсөлд хөрөнгө оруулалт татах хэлбэр, механизм, арга замууд нэмэгдсэн** байна.

» ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ЗАРЧИМ

- Чухал ашигт малтмалын жагсаалтыг Засгийн газар батлах;
- Улсын төсвөөс геологийн судалгааны ажилд жил бүр зарцуулдаг зардлын 20 доошгүй хувийг Чухал ашигт малтмалын геологийн судалгааны ажилд зарцуулах;
- Чухал ашигт малтмалыг баяжуулалт, боловсруулалт хийхгүйгээр түүхийгээр нь экспортод гаргахыг хориглох;
- Чухал ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох.

Монгол улс чухал ашигт малтмалын чиглэлээр хурдтай, идэвхитэй ажиллаж, сорилтыг боломж болгон, эрсдэлийг бууруулна.



» БАЯЖУУЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААР



78 Тусгай зөвшөөрөлтэй баяжуулах үйлдвэр

Ашигт малтмалын төрлөөр	
Төмөр	24
Алт	17
Хайлуур жонш	5
Нүүрс	5
Полиметалл	8
Гянтболд	6
Зэс	4
Бусад	9
Нийт	125

47 Өөрийн ордгүй баяжуулах үйлдвэр

Өөрийн ордгүй баяжуулах үйлдвэр	
Төмөр	16
Хайлуур жонш	14
Нүүрс	9
Алт	7
Зэс	1
Нийт	47

Тусгай зөвшөөрөлгүйгээс үүсэж буй хүндрэлтэй байдал

- ▶ Түүхий эд гарал үүсэл нь тодорхойгүй;
- ▶ АМНАТ ногдуулахад хүндрэлтэй;
- ▶ Баяжуулах үйлдвэрт чиглэсэн технологийн болон эдийн засгийн тусгай бодлого хэрэгжүүлэх шаардлага үүссэн;
- ▶ Үүсмэл ордын зохицуулалтыг тодорхой болгох шаардлага бий болсон;
- ▶ Баяжуулах үйлдвэрийг зохицуулсан эрх зүйн орчин тодорхойгүй.


Тусгай зөвшөөрөлтэй болсон давуу тал

- ▶ Хуулиас гадуур баяжуулалтын үйл ажиллагаа явуулснаас үүдэн гарах хууль, эдийн засаг, эрүүл мэндийн эрсдэлээс хамгаална;
- ▶ Төрийн нийтийн өмч болох ашигт малтмалыг үнэгүйдүүлэхээс сэргийлэх боломж бүрдэнэ /АМНАТ/;
- ▶ Хуулийн зорилгод тусгасан хариуцлагатай уул уурхайн зорилт руу чиглүүлнэ;
- ▶ Баяжуулах үйл ажиллагааг өмнө нь журмаар зохицуулж ирсэн ба харилцааг нэг мөр болгон салбарын хуульд тусгасан;
- ▶ Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэгчдэд чиглэсэн тусгайлсан бодлого хэрэгжүүлэх боломж бүрдэнэ;
- ▶ Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг бүрэн хэмжээнд эдийн засгийн эргэлтэд оруулах ач холбогдолтой;
- ▶ Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа хумигдана;

» БАЯЖУУЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААР


Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс харахад:

Тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжийн баяжуулсан бүтээгдэхүүний экспорт, мян.тн



Нийт тусгай зөвшөөрөлгүй баяжуулсан бүтээгдэхүүн экспортолсон аж ахуйн нэгжийн тоо

96 ААН



Уулын ажлын төлөвлөгөө, тайлан батлуулдаг

21 ААН

75 ААН???

Бүтээгдэхүүн	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Гянтболд	0.36	-	0.16	0.12	0.08	-	-
Зэсийн баяжмал	0.60	-	-	-	0.32	0.28	-
Катодын зэс	30.09	9.65	9.85	10.01	12.55	13.14	14.74
Нүүрс	259.15	5.25	3.77	39.12	14.44	10.37	554.45
Төмөр	1,455.69	308.42	262.92	108.13	101.92	65.87	45.83
Үнэт металл	0.18	-	-	-	-	0.02	-
Хайлуур жонш	213.35	42.95	43.95	18.22	45.46	22.62	64.18
Хар тугалга	-	-	-	-	-	-	0.17
	1,959.4	366.3	320.6	175.6	174.8	112.3	679.4

» ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

- ❖ салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгд оролцох, санал, зөвлөмж өгөх;
- ❖ салбарын байгууллагуудтай хамтарсан судалгаа хийх;
- ❖ салбарын хүний нөөц, техник, технологийн хөгжил, чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах;
- ❖ .холбогдох төрийн байгууллагаас геологи, уул уурхайн салбарын талаар үнэн, зөв мэдээлэл авах
- ❖ эдийн засгийг хөгжүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр геологи, уул уурхайн салбарт төрөөс баримталж буй бодлогыг дэмжих, энэхүү бодлогыг алдагдуулах, зогсоох аливаа явцуу ашиг сонирхолд оролцохгүй байх;
- ❖ ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдэгдэх, гомдол гаргах.”

» АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР (БАТ)



АМНАТ

АМНАТ-ИЙН НЭРШЛИЙГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭХ

Зэсийн АМНАТ

- ▶ Бичил уурхай эрхлэгчийг АМНАТ төлөгч болгох;
- ▶ Зэсийн АМНАТ-ийн хувь хэмжээг бууруулах;
- ▶ Орон нутгийн хуваарилалт;
 - ❖ Нөлөөлөлд өртөх аймаг, сумд – 30 %
 - ❖ Орон нутгийн нэгдсэн хөгжлийн санд төвлөрүүлэх орлого – 15%
- ▶ Баяжмалын суурь төлбөр 5.0%;
- ▶ Нэмж ногдуулах төлбөр /0-5%/;



Онцлог
зохицуулалт

- Төсвийн тухай хуулийн 59.1.2 дахь заалтад өөрчлөлт оруулах;
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжсан арилжааны үнийн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн;”
- Зэсийн баяжмалын дагалдах элементийн АМНАТөлбөрийг одоогийн Ашигт малтмалын тухай хуулийн 47.5-д заасны дагуу тогтоох асуудлыг УИХ шийдвэрлэх;

ЖУРАМ, СТАНДАРТ, ШААРДЛАГА, ЖАГСААЛТ БАТЛАХ

Монгол Улсын Их Хурал батална.

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын жагсаалт;

Монгол Улсын Засгийн газар батална.

1. Чухал ашигт малтмалын жагсаалт;

Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлана.

1. Техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага;
2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээний загвар;
3. Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх, уул уурхайн технологийн зураг төсөл боловсруулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааны журам;

ХУУЛИЙГ ДАГАЛДАЖ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгох тухай;
2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
3. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
4. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
5. Ирээдүй өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
6. Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
7. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
8. Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
9. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
10. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
11. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай;
12. Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
13. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
14. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай;
15. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай;

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд доорх
хаягт саналаа ирүүлэхийг хүсье.

user@mmhi.gov.mn

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ





АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА

☎ +976 (51)-263506

✉ info@mmhi.gov.mn

📍 Хаяг: Монгол Улс, Улаанбаатар,
Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,
Засгийн газрын II байр



🌐 www.mmhi.gov.mn